



ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАХИРГААНД

**ЗАВХАН АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/факс: 7046-3702
И-мэйл: zavkhan.mhg2018@gmail.com

2022.11.16 № 07-07-027/154

Барилгын ашиглалтын төлөв
байдлын тухай

Тус газарт Эрдэнэхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн захиргаанаас ирүүлсэн тус сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах цэцэрлэгийн барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах тухай хүсэлт, Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталсан "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 07/14 дугаартай удирдамжийн хүрээнд тус цэцэрлэгийн барилгын ашиглалтын төлөв байдалд шалгалт хийж Барилгын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн боловсруулсан норм ба дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Р.Цэцэгмааг байлцуулан газар дээр нь үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Барилгыг цэцэрлэгийн зориулалтаар аж ахуйн аргаар барьсан, шугаман бетон суурьтай, дүнзэн даацын ханатай, модон хучилттай, шувуун нуруу бүхий төмөр дээвэртэй, цахилгаан, дулааны төвлөрсөн сүлжээнд холбогдсон 2006 онд ашиглалтад оруулсан, 1 давхар барилга байна.

Барилгад мөөгөнцөр үүссэн хана, шалыг хэсэгчлэн засах ажлыг 2014 онд, дээврийн төмөр хучлагыг солих, мөөгөнцөртсөн хана, шалыг хэсэгчлэн засах, цонх, хаалга бүрэн шинэчлэх зэрэг засварын ажлыг 2017 онд хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалт хийх үеийн нөхцөл байдал:

5.2 кодтой барилгын ашиглалтыг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлт 53, эрсдэл үүсэх магадлал 45% буюу "дунд эрсдэлтэй" үнэлэгдсэн.

1. Барилга байгууламжийн паспортжуулалт хийгдээгүй, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт болон барилгын техникийн бичиг баримтгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дахь заалтыг;

2. Барилгын дотор даацын модон хананд мөөгөнцөр хэсэгчлэн үүсэж даац авах чадвараа алдсан, модон хучилт хотойх, нурах эрсдэл үүсч болзошгүй зэрэг нь Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар БД131-99-ийн шаардлагыг;

3. Хананд үүссэн мөөгөнцрөөс үүдэн барилгад ажиллаж буй багш ажилчид, сурч хүмүүжиж буй хүүхдийн эрүүл мэндэд шууд ба шууд бусаар сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн зэрэг нь "Барилга ашиглалтын дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх хэсэгт заасан Хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх гэсэн заалтыг тус тус хангахгүй байна.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

1. Эрдэнэхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын үндсэн хийц бүтээц болох дотор даацын модон хананд үүссэн мөөгөнцөр, гэмтэл нь барилгын ашиглалтын хэвийн нөхцөл, бүтээцийн найдвартай ажиллагааг хангахгүй, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг алдагдуулсан байна.

2. Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд ерөнхий үзлэгийг зохион байгуулж, үүссэн гэмтлийг засварлах ажлыг үе шаттайгаар мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллан ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах нь зүйтэй байна.

3. Барилга байгууламжийн техникийн баримт бичгийг бүрдүүлэх, баяжилт хийх, барилгыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх ажлыг хийж гүйцэтгэн, хүүхэд багачуудын сурч, хүмүүжих, багш, ажиллагсдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичиг дүгнэлтийг эс зөвшөөрвөл Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.БАТ-УЧРАЛ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН
ЭРХЛЭГЧ

Р.ЦЭЭЦЭГМАА



Гарын үсэг зурахаас татгалзсан тайлбар:.....